

(1986) гэх зэргийн олон зохиолыг гадаад хэлнүүдээс орчуулж монголоор хэвлэжээ.

ӨМӨЗО-нд сүүлийн жилүүдэд хэвлэсэн монгол түүх судлалын бүтээлийг товч тоймлоход ийм байна.

Өвөр Монголын эрдэмтэд ойрын ирээдүйд Өвөр Монголын ойллого, Өвөр Монголын үндэстний ойллого, Өвөр Монголын нэвтэрхий түүхийг олон ботиор гаргахаар шамдан ажиллаж байна. Өвөр монголчууд бол БНХАУ-ын цөөн тоот үндэстний нэг төдийгүй суугуул нутагтаа бас хүн амын цөөнх тул монгол түүх судлалын гол бүтээлүүдээ юуны урьд тус улсын олон үндэстний харилцааны нийтлэг хэрэглүүр болж байгаа хятад хэлээр хэвлүүлж, үндэстнээ хэрхэн мэдэрч, түүхээ яаж судлаж байгаагаа хятад болон бусад үндэстнүүддээ мэдүүлэхийг урьдал болгодог тул бараг бүх бүтээл нь хятад монгол хаёр хэлээр нийтлэгддэг бололтой. Өвөр Монгол бол бүх монгол үндэстэн биш түүний зөвхөн нэг томхон хэсэг нь билээ. Иймд эх түүхийнхээ судлалаар тэдний олсон ололт нь тухайн улс орны үндэстний бодлого, эрдэмтэдийн идэвх зүтгэлээр тодорхойлогдох бөгөөд Монгол улс, Оросын холбооны улс дахь Монгол угсааны улсуудад нэгийг бодогдуулах нь мэдээж. Монгол түүх судлал зөвхөн уг үндэстэн, угсааны улс, орон төдийгүй олон улсын судлагдахуун болсон өнөө үед судалгаанд нэг загварын хэвшмэл үзэл бодлыг ягшихгүй олон ургалт үзлийг уралдуулан харилцан ойлголцож, хамтран ажиллавал нэн их амжилтад хүрэх нь дамжиггүй.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

**Б. Б. БАРАДИН (1878—1937)**

**С. А. Максанов**

Базар Барадиевич Барадин Агын буриад Барадий Боронжоевын гэрт төрсөн бөгөөд түүний 11 хүүхдийн ууган нь юм. Түүний эцэг нь тухайн үедээ боловсролтой хүн байв.

Базар Агын дөрвөн ангитай сургуулийг дүүргээд Чит хотын гурван ангитай сургуульд орж суралцсан боловч төгсгөлгүй 1895 онд Петербурgt очиж П. Бадмаевын гимназид суралцаж байгаад 1900 онд нутагтаа буцаж иржээ.

1902 онд Жамсрангийн Цэвээнтэй хамт Петербургийн Их сургуулийн дорно дахины хэлний салбарт орсон. 1908—1917 онд Барадин их сургуульдаа монгол хэлний багшаар ажиллаж профессор цол хүртсэн.

Тэр их сургуульд орохоосоо өмнө Герман, Итали, Швейцариар аялж, өрнөдийн хэлүүд судалж байв. Их сургуульд суралцаж байхдаа ч гэсэн Европын орнуудаар явж, англи, герман, франц хэлийг эзэмшсэн. Их сургууль төгссөнийхөө дараа Төвдөөр аялж буддизмын тухай судалгааны хэдэн өгүүлэл бичсэн.

Б. Барадин 1905—1907 оны хувьсгалын жилүүдэд оюутан байхдаа нийгэм улс төрийн үйл ажиллагаагаа эхэлж буриадын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд оролцсон. Буриадын анхдугаар их хурлын ажлын үед буриадад үндэсний өөрийн захиргааг бий болгох, буриадын соёлыг хөгжүүлэхийн төлөө идэвхтэй тэмцэж байв. Б. Барадин бол шарын шашныг шинэчлэх хөдөлгөөнийг үүсгэгч, үзэл сурталчдын нэгэн билээ. Бүр 1905 онд тэрээр Жамсрангийн Цэвээнтэй хамтран Виттед лам нарыг буддынхан гэж өөрчлөн нэрлэх хүсэлт тавьж

байсан агаад сургуулиудад бурхны сургаалыг заах хөтөлбөрийг 1912 онд зохиож байжээ.

1917 оны хоёрдугаар сарын хувьсгал нь Оросын дарлагдсан ард түмнүүдийн тухайлбал, буриадын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг хөгжөөж өрнүүлсэн билээ. 1917 оны 3 дугаар сард Петроградад Буриад-Халимагийн хороо байгуулагдахад Барадин түүнд орсон. Тэр хороо нь зохион байгуулах хурал, түр засгийн газрыг Буриад, Халимагийн ард түмнүүдийн нийгэм-эдийн засаг, улс төрийн амьдралын асуудлуудыг шийдэж чадахуйц байгууллагууд гэж найдсан, үзэл суртал-улс төрийн агуулгаараа хөрөнгөтний үндсэрхэг үйл ажиллагааны хөтөлбөр дэвшүүлэн гаргасан билээ. Гэтэл түүний ажиллагаа хийгээд уг хороо оршин байх нь Буриад-Халимагийн ард түмнүүдийн тэргүүний олон нийтийн шийдэмгий эсэргүүцэлтэй тулгарч мухардсан тул задарсан юм.

Буриадад эрчимтэй өрнөсөн нийгэм-улс төрийн үйл явдал нь Б. Барадинг эх нутагтаа буцаж ирэхэд хүргэв. 1917 оны 7 дугаар сарын дундуур Галуут нуурын дацанд болсон нийт буриадын хоёрдугаар их хурлын ажиллагаанд тэр идэвхтэй оролцсон бөгөөд уг их хурал шарын шашныг шинэчлэх хөдөлгөөний талынхны үзэл санаа, шаардлага болсон «захиас»-ыг баталсан. Их хурлын «захиас» ба бусад шийдвэрүүд нь Буриадын үндэсний хорооны төлөөлөгчид хийгээд «хуучныг баримтлагчид»-тай<sup>2</sup> лам нарын доторх шинэчлэх хөдөлгөөний хошуучлагчдаас хийсэн шургуу тэмцлийн хамтын чармайлтаар батлагдсан юм. Энэ үеэс Б. Барадины нийгэм-улс төрийн үйл ажиллагааны шинэ шат эхэлсэн билээ. Б. Барадин 1917 оноос Агинскд багшийн түр сургуульд ажиллахын зэрэгцээгээр хичээлийн гарын авлага бэлтгэх, театрын тоглолт зохион байгуулах, бүтээлч ажиллагаа эрхлэх болсон. Тэрээр 1917—1918 онд буриад хэлний «үсэглэл», унших бичиг «улаан цэцэг», сүүлд «Жигдэн» гэдэг алдарт зохиол болгон засварласан «Хуучин ноёд» гэдэг инээдмийн жүжиг зохиосон болай.

Петроградад 10 сарын хувьсгал ялсан тухай мэдээг тэр Буриадын үндэсний хорооны бүх зүтгэлтний адил баярлан угтаагүй, Өвөр Байгальд зөвлөлт засаг тогтсонд тааламжтай биш хандаж байлаа. Өөрийн адил сэтгэлтэн Жамсрангийн Цэвээнийг Б. Барадин 1918 оны 9 дүгээр сард Буриадын үндэсний хорооны тэргүүлэх зүтгэлтний нэг гэж тодорхойлоод «Зөвлөлт засгийн халдлагаас үндэсний захиргаагаа өмгөөлөх талаар амь биеэ хайрлахгүй ажилласан түүнд талархал илэрхийлэх»<sup>3</sup>-ийг санал болгож байв. Тэр Агын аймгийн Цугол хошууны гүйцэтгэх Хорооны даргын хувьд Их Монгол улс байгуулах санааг дэмжиж байв. Бас 1919 оны 2 дугаар сард Читад Их Монголын бага хуралд очиж байгаа буриадын төлөөлөгчдийг хүлээн авахыг японы эзэн хаанд гуйсан шударга албатын өргөдөл бичсэн.<sup>4</sup>

Семеновынхныг устгаж японы довтлогчдыг Өвөр Байгалиас үлдэн зайлуулж 1920 оны 4 дүгээр сард Алс Дорнодын Бүгд Найрамдах Улсыг (АДБНУ) байгуулсны дараа Б.Барадин нэг хэсэг нийгэм-улс төрийн үйл ажиллагаанд идэвхгүй болсон. Үндэсний ардчилсан зүтгэлт нүүдээр удирдуулсан АДБНУ-ын Буриадын автономит муж байгуулагдсаны дараа тэр «Буриадын үндэсний соёлын» «БҮС» нийгэмлэгийн үзэл сурталч, зохион байгуулагч болон гарч ирсэн. Энэ нийгэмлэг үндэсний ардчилсан соёлын үзэл санааг номлож байв.<sup>5</sup>

Б. Б. Барадин энэ жилүүдэд утга зохиолын уран бүтээлийн ажиллагаагаа үргэлжлүүлж «Чойжит хатан» гэдэг яриан жүжгийг 1920 онд бичиж, тайзан дээр тоглуулсан. 1921 онд Буриад Оросын харилцааны тухай шинэ ном зохиол бичсэн.

АДБНУ-ын Буриадын автономит мужийн удирдлагад коммунистууд орж Оросын Коммунист (б) Нам (ОК (б) Н) -ын Буриадын мужийн хорооны заавраар 1922 оны эхээр автономит мужийн захиргааны коммунист бүлэг «БҮС»-ын нийгэмлэгийн мөрийн хөтөлбөрийг үндсээр нь хянан үзэх замаар, уг нийгэмлэгийг устгах арга хэмжээ авахын тул хариуцлагатай ажилтан коммунистуудаас бүрдсэн тусгай комисс байгуулсан.<sup>6</sup>

ОК(б) Н-ын Төв Хороо, Зөвлөлт засгийн газрын улс олон нийт, соёлын ажилд хуучин сэхээтний төлөөлөгчдийг татан оролцуулах нь чухал гэсэн заалтыг баримтлан ОК(б) Н-ын Буриадын мужийн Хороо, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улс (ЗСБНХОУ) ба АДБНУ-ын Буриадын автономит мужийн захиргааны байгууллагууд Б. Барадинг төрийн байгууллагын ажилд урьсан. Тэр профессор Ц. Г.Цыбиковын зэрэгцээгээр АДБНУ-ын ардын боловсролын удирдах газрын хэлстийг толгойлох болсон билээ.<sup>7</sup> Б. Барадин энэ ажлыг хийж байхдаа үсэглэл болон буриад хэлээр унших ном бэлтгэж хэвлүүлсэн бөгөөд хоёрдугаар зэргийн үндэсний сургуульд үзэх хэдэн сурах бичиг хэвлэлд бэлтгэсэн.

ОК(б) Н-ын Буриадын мужийн Хороо, автономит мужийн төрийн байгууллагууд Б. Барадины засаг захиргааны зохион байгуулагч авьяас, сургууль гэгээрэлд оруулсан практик хувь нэмрийг үнэлж байсан. Иймээс 1923 онд Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Автономит улс байгуулагдахад Б. Барадин Бүгд Найрамдах улсын анхны гэгээрлийн арлын комиссараар томилогдсон юм. Гэвч түүний үзэл санаа, соёлыг хөгжүүлэх асуудлыг ойлгох нь мужийн намын байгууллагын үзэл, шийдвэртэй хурц зөрчилдөж байлаа.

Б. Барадин энэ жилүүдэд эрдэм шинжилгээ, нийтлэлийн ажиллагааг эрчимтэй явуулж үндэсний соёлын байгуулалтын асуудлаар өөрийн үзэл бодлыг илэрхийлж байв. Тэрээр 1924 оны эхээр Маркс-Лениний ба Буддизмын сургаалыг адилтгасан санаа дэвшүүлсэн.<sup>8</sup> Буриадын соёлын байгуулалтын нэг нөхцөл бол бүх буриалыг шилжүүлэн суулгах замаар үндэсний нэгдмэл цул нутаг дэвсгэр бий болгох нь» зайлшгүй гэж тэр тавьсан. Буриадын үндэсний соёл нь соёл, үзэл суртлын хувьд юуны урьд Энэтхэг-Буриадын соёлын ололт, туршлагыг ашиглахад чиглэх бөгөөд Буриад бол соёл-үзэл суртлын талаар Монголын хэсэг гэж үзэж байлаа. Тэднийг эрж байгаа үндэсний соёлтой ойртуулахын тул Энэтхэг буддын соёлыг, Европынхтой ойртуулах нь зайлшгүй хэрэгтэй гээд буриадын тайзны урлагийн асуудлаар ярихдаа бөө мөргөлийг хэтэрхий магтаж байна хэмээн хэлж байв.<sup>9</sup>

Б. Барадин 1925 онд Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах автономит Буриад улсын Гэгээрлийн ардын комиссарын үүргээс чөлөөлөгдсөн. ОК(б)Н-ын буриадын мужийн намын хороо, бүгд найрамдах улсын засгийн газар түүний мэдлэг чадварыг шинжлэх ухааны талд ашиглахын тул тус улсын Шинжлэх ухааны хүрээлэнгийн захирлаар томилсон. Хариуцлагатай шинэ ажилд томилогдсон, тавин нас хүрч байсан Б. Барадинд Марксч-Ленинч байр суурьт таарч зохиох нь бэрх төвөгтэй байв. Тэр эрдэм шинжилгээний бүтээлүүддээ үндэсний соёлын байгуулалтын асуудлаар урьдын баримталж байсан үзэл бодлоо хамгаалсаар байв.<sup>10</sup>

Бүх Холбоотын Коммунист (Большевикуудын) Намын Төв Хороо 1929 оны 5 дугаар сарын 27-нд «Буриад Монголын намын байгууллагын ажил байдлын тухай» тогтоол баталсан. Түүний үндсэн дээр улс орны хэмжээгээр нам-улс төр, нийгэм-эдийн засаг ба соёл-үзэл суртлын

амьдралыг өөрчлөн байгуулав. Үүнтэй холбогдож, Б. Барадин Шинжлэх ухааны хүрээлэнгийн захирлын тушаалаас чөлөөлөгдөж, соёлын институтын бааз дээр байгуулагдсан хүрээлэнгийн захирлын орлогчоор ажиллах болсон.

Б. Барадин «Буриадын соёл» сэтгүүлийн газар захидал бичиж, түүндээ буриад дахь үзэл суртлын ажил, соёлын байгуулалтын асуудлуудаар гаргасан алдаагаа хүлээн зөвшөөрсөн.<sup>11</sup>

Буриадын нөхцөлд социализмыг байгуулах хийгээд үндэстний асуудлыг шийдвэрлэх талаар гарсан амжилт, түүнийг зарим алдаагаа ухамсарлахад хүргэсэн байх. Тус улсад үзэл суртал, соёлын байгуулалтын зарим асуудлаар түүний үзлийг шүүмжлэхдээ ямагт үндэслэлтэй, эелдэг байгаагүйг бас хэлүүлтэй.

Б. Б. Барадин хэлний шинжлэлийн талаар эрдэм шинжилгээний ажлыг үр бүтээлтэй эрхэлж, буриадын шинэ утга зохиолын хэлний зүй, буриад хэлний зүй, Орос-Монгол нэр томъёоны толь бичиг, буриад хэлний өгүүлбэр зүй гэх зэргийн зохиолууд бичсэн нь хэлний байгуулалтад их үүрэг гүйцэтгэсэн ажээ. Тэр олон нийтэд зориулсан утга зохиолыг орос хэлнээс буриадаар орчуулах талаар их цаг зарж анхаарч байсан юм.

Буриадын хуучин сэхээтний төлөөлөгчид алдаа гаргаж, гуйвж дайвж байвч ард түмнийхээ сонирхолд үнэнч үйлчилж тэдний соёлын ба материаллаг амьдралын төвшинг дээшлүүлэхийн төлөө өөрсдийн хүч мэдлэгээ зориулж байсан нь Б. Барадины жишээнээс харагдаж байна.

1. Хаптаев П. Т. Октябрьская Социалистическая революция и гражданская война в Бурятии (Октябрийн социалист хувьсгал ба Буриад дахь иргэний дайн) Улан-Удэ. 1964. с. 154, 156
2. Герасимова К. Н. Обновленческое движение Бурятского духовенства (Буриадын шарын шашны санваартны шинэчлэлийн хөдөлгөөн). Улан-Удэ. 1964, с. 24
3. Партархив. Иркут. ОК, КПСС (ЗХУКН-ын Эрхүү мужийн Хорооны Намын архив) Ф. 123, оп. 4. д. 355, лл. 101, 102, 106
4. Цыбиков Б. Д. Цыбен Жамцарано (к 80 летию со дня рождения). Жамсрангийн Цэвээн төрсний 80 жилийн ойд. Труды БКНИИ СО АН СССР-Из истории народов Бурятии (Буриадын ард түмний түүхээс). Улан-Удэ. 1962. с. 137
5. Партархив. Иркутск. ОК КПСС (ЗХУКН-ын Эрхүү мужийн Хорооны Намын архив), Ф. 123. оп. 4. д, 355, л. 116
6. Партархив. Бур. ОК КПСС (ЗХУКН-ын Буриадын мужийн Хорооны архив). Ф. 1, оп. 1. д. 29. л. 24, д. 49, л. 19
7. Егунов Н. П. М. И. Амагаев, Улан-Удэ, 1974. с. 40
8. Партархив. Бур. ОК КПСС (ЗХУКН-ын Буриадын мужийн Хорооны архив). Ф. 1. оп. 1, л. 29, с. 24
9. «Культура Бурятия» (Буриадын соёл) сэтгүүл 1932. № 2. с. 28, 29.  
«Жизнь Буряти» (Буриадын амьдрал) сэтгүүл. 1924. № 6. с. 80
10. «Культура Бурятии». 1932. № 2. С. 29
11. «Культура Бурятии». 1932. № 2. С. 29 Национально-освободительное движение Бурятского народа (Буриадын ард түмний үндэстний эрх чөлөөний хөдөлгөөн) Улан-Удэ. 1989 гэдэг номын 76—80 дугаар талаас Л. Жамсран орчуулав.